



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн хэрэгжилтийг хангуулах, албан хаагчдын ажилласан цагийг бүртгэх төхөөрөмжийг хуульд нийцүүлэн мэдээлэл эзэмшигчийн зөвшөөрлийг авч тохируулах, хурууны хээг устгах ажиллагааг актаар баталгаажуулан ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга  
Гишүүд: Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хяналт,  
шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн  
Нарийн бичгийн дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн Хүний нөөцийн  
хөгжил, сургалт хариуцсан ажилтан

2. Хуулийн хэрэгжилтийг шуурхай хангуулан, холбогдох тайлан мэдээг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний дотор тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэгт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (О.Оджаргал)-д даалгасугай.

ДАРГА



О.ТӨМӨРДУЛАМ

1150500107